**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 08 өдөр　　　　Дугаар А/149　　　　Арвайхээр

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны “Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” А/89 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтан их хэмжээгээр тархсан Зүүнбаян-Улаан, Өлзийт, Есөнзүйл, Тарагт, Нарийнтээл, Хайрхандулаан, Хужирт, Хархорин сумдын 70.0 мянган га бэлчээрт энгийн механик биологийн аргаар тэмцэх ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Сумдын бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх талбайн хэмжээ, зардлын хуваарилалтыг хавсралтаар батлсугай.

3. Мэрэгч амьтантай тэмцэх ажилд сумын ажилгүй иргэд, малчид, малчдын бүлэг хоршоог хамруулж тэднийг мэрэгч устгалын гарын авлага, шаардлагатай техник хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах болон цаг агаарын саатлаас бусад тохиолдолд ажил саатахгүй байх бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээг авч, хууль журмын дагуу хяналт тавьж ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дээрх ажлыг эхлүүлж, сумын Засаг дарга нартай гэрээ байгуулан ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), сумдын Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудыг татан оролцуулж, боломжит тооны хүн хүч, техник хэрэгсэл дайчлан ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар, дэд хурандаа (Т.Мөнхдорж), уг ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА　　　　Г.ГАНБОЛД

011100321

D:My Doc. Zahiramj. Zasag darga

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 08 өдөр Дугаар А/149 Арвайхээр

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны "Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай" А/89 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтан их хэмжээгээр тархсан Зүүнбаян-Улаан, Өлзийт, Есөнзүйл, Тарагт, Нарийнтээл, Хайрхандулаан, Хужирт, Хархорин сумдын 70.0 мянган га бэлчээрт энгийн механик биологийн аргаар тэмцэх ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Сумдын бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх талбайн хэмжээ, зардлын хуваарилалтыг хавсралтаар батлсугай.

3. Мэрэгч амьтантай тэмцэх ажилд сумын ажилгүй иргэд, малчид, малчдын бүлэг хоршоог хамруулж тэдний мэрэгч устгалын гарын авлага, шаардлагатай техник хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах болон цаг агаарын саатлаас бусад тохиолдолд ажил саатахгүй байх бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээг авч, хууль журмын дагуу хяналт тавьж ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дээрх ажлыг эхлүүлж, сумын Засаг дарга нартай гэрээ байгуулан ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), сумдын Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудыг татан оролцуулж, боломжит тооны хүн хүч, техник хэрэгсэл дайчлан ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар, дэд хурандаа (Т.Мөнхдорж), уг ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.ГАНБОЛД

011100321

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2020 оны .04.
дугаар сарын .08-ны өдрийн А/149 дугаар
захирамжийн хавсралт

# СУМДЫН БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ МЭРЭГЧ АМЬТАНТАЙ ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

| д/д | Сум, байгууллагын нэр | Мэрэгчтэй тэмцэх талбайн хэмжээ га | Зарцуулах хөрөнгө /мянган төгрөг/ | Зарцуулах зориулалт |
|---|---|---|---|---|
| 1 | Зүүнбаян-Улаан | 8750 | 12600.0 | Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин /урамшуулал/, шатахууны зардал |
| 2 | Есөнзүйл | 8750 | 12600.0 | Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин /урамшуулал/, шатахууны зардал |
| 3 | Тарагт | 8750 | 12600.0 | Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин /урамшуулал/, шатахууны зардал |
| 4 | Нарийнтээл | 8750 | 12600.0 | Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин /урамшуулал/, шатахууны зардал |
| 5 | Хайрхандулаан | 8750 | 12600.0 | Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин /урамшуулал/, шатахууны зардал |
| 6 | Өлзийт | 8750 | 12600.0 | Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин /урамшуулал/, шатахууны зардал |
| 7 | Хужирт | 8750 | 12600.0 | Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин /урамшуулал/, шатахууны зардал |
| 8 | Хархорин | 8750 | 12600.0 | Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин /урамшуулал/, шатахууны зардал |
| 9 | Хүнс, хөдөө аж ахуйн газар | | 11200.0 | Ажлын хэсгийн зардал |
| Дүн | | 70.0 | 112000.0 | |

-оОо-